

**Зарим дүрэм, журамд
өөрчлөлт оруулах санал**

Хуучин	Шинэ
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ	
4.2.9.7. Сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоож, Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэх;	4.2.9.7. Сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох саналыг хэлэлцэж, Удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлэх;
6.1.1. Эрдмийн зөвлөл үндсэн нэгжийн эрдмийн зэрэгтэй багш, эрдэм шинжилгээний ажилтан (гэрээт багш, гэрээт эрдэм шинжилгээний ажилтан орохгүй) нараас бүрдэнэ.	6.1.1. Эрдмийн зөвлөл нь 30 хүртэл эрдмийн зэрэгтэй багш, эрдэм шинжилгээний ажилтан (гэрээт багш, гэрээт эрдэм шинжилгээний ажилтан орохгүй) бүхий сургуулийн хувьд эрдмийн зэрэгтэй бүх хүнээс бүрдэнэ. <u>Харин 30-50 хүнтэй бол 2/3, 50-иас дээш бол 2 хүн тутмаас нэгийг сонгох замаар бүрдүүлнэ.</u>
6.1.2. Эрдмийн зөвлөлийн даргыг эрдмийн зөвлөлөөс сонгоно.	6.1.2. <u>Үндсэн нэгжийн захирал нь</u> эрдмийн зөвлөлийн дарга байна.
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ПРОФЕССОР, БАГШ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ	
10.1. Багш нарын үндсэн цалингийн (эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх мэтийн бусад эх үүсвэрийн орлого хамаарахгүй) сүлжээг профессорын албан тушаалын цалинтай харьцуулан тогтооно: Албан тушаал Ажилласан жил Харьцуулсан цалин 1) Профессор 15 жил 100% 2) Дэд профессор 15 жил 88% 3) Ахлах багш 15 жил 80% 4) Багш 7 жил 75% 5) Дадлагажигч багш 2 жил 55%	10.1. Багш нарын цалингийн (<u>эрдмийн зэргийн нэмэгдлийн хамт</u>) сүлжээг профессорын албан тушаалын цалинтай харьцуулан тогтооно: Албан тушаал Ажилласан жил Харьцуулсан цалин 1) Профессор 15 жил 100% 2) Дэд профессор 15 жил 88% 3) Ахлах багш 15 жил 80% 4) Багш 7 жил 75% 5) Дадлагажигч багш 2 жил 55% <u>Эрдмийн цолны нэмэгдэл, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх мэтийн бусад эх үүсвэрийн орлого энд хамаарахгүй.</u>
1.8. Тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаар ахлах багшийн хувьд хуульд заасны дагуу буюу 60, докторын зэрэгтэй, дэд профессор юмуу профессор цолтой багшийн хувьд 63, шинжлэх ухааны докторын хувьд 65 байна.	<u>Хасах</u>
4.9. МУИС-д зохих шаардлагыг бүрэн ханган, багшилж байгаад докторантурт элсэн амжилттай суралцаж, эрдмийн зэргээ хамгаалсан эрдэмтнийг шалгалтгүйгээр багшийн ажилд авч болно.	4.9. МУИС-д зохих шаардлагыг бүрэн ханган, <u>үндсэн</u> багшаар ажиллаж байгаад докторантурт элсэн амжилттай суралцаж, эрдмийн зэргээ хамгаалсан эрдэмтнийг шалгалтгүйгээр багшийн ажилд авч болно.
4.6. Шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхим/профессорын багийн саналыг харгалзан гадаад хэлний шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн хүнээс өөр гадаад хэл бичгийн шалгалт авах асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар тусгайлан шийдвэрлэнэ.	4.6. Гадаад хэлний шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн хүн <u>өөрөө хүсэлт гаргавал</u> өөр гадаад хэлний шалгалт авах асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар тусгайлан шийдвэрлэнэ.
4.10. Тухайн салбартаа нэрд гарсан эрдэмтнийг шалгалтгүйгээр урьж ажиллуулж болох бөгөөд энэ тухай тэнхим, лаборатори, профессорын багийн хурлын тэмдэглэлийг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн	4.10. Тухайн салбартаа нэрд гарсан эрдэмтнийг шалгалтгүйгээр урьж ажиллуулж болох бөгөөд энэ тухай тэнхим, лаборатори, профессорын багийн хурлын тэмдэглэлийг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл

<p>зөвлөл дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргасан байна. 50, 25 хувийн ажлын ноогдолтой гэрээт багш авахдаа үүний нэгэн адил шийдвэрлэнэ.</p>	<p>дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргасан байна. Эрдмийн зэрэгтэй хүнийг 50, 25 хувийн ажлын ноогдолтой гэрээт багшаар авахдаа үүний нэгэн адил шийдвэрлэнэ.</p>
<p>6.6. Дэд профессорын орон тоонд ажиллах багш дээрх ерөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна: Профессорын орон тоонд ажиллах багшид дараах тусгай шаардлага тавина:</p>	<p>6.6. Дэд профессорын ажлын байранд тавигдах дээрх ерөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна: Профессорын ажлын байранд дараах тусгай шаардлага тавина:</p>
<p>МУИС-ИЙН БАГШИЙН АЖЛЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ (АТТЕСТАТЧИЛЛЫН) ЖУРАМ</p>	
<p>7.1. А (90-100): Ийм үнэлгээ авсан багшийн ажлын үр дүнг хангалттай сайн гэж үзэх бөгөөд түүний албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлалыг ахиулж болох бөгөөд энэ асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.</p> <p>7.2. В (80-89): Эрхэлсэн ажилдаа хангалттай тэнцэж байна гэж үзэх ба оноог харгалзан цалингийн шатлалыг ахиулж, урамшуулал олгож болно.</p> <p>7.3. С (70-79): Ажилдаа тэнцэж байна гэж үзэх ба гэхдээ багш аль үзүүлэлтээр бага оноотой үнэлэгдсэндээ дүгнэлт хийж цаашид анхаарч ажиллах ёстой.</p> <p>7.4. Д (60-69): Ажлын үзүүлэлт хангалтгүй гэж үзэх ба албан тушаалыг нь нэг зэрэглэлээр бууруулна. Хэрвээ хүндэтгэн үзэх шалтгаантай бол сургууль, тэнхим/профессорын багаас тухайн багшид нэг жилийн хугацаатай даалгавар өгч, дараагийн хичээлийн жилийн аттестатчилалд дахин орох боломж олгоно. Энэ үндэслэлээр зэрэглэл буурсан багшийн хувьд дараагийн аттестатчиллын үр дүнгээр өмнөх зэрэглэлдээ дэвшин ажиллах эрх нь хадгалагдана. Дахин аттестатчилалд орохоос таггалзвал хөдөлмөрийн гэрээг цуцална.</p> <p>7.5. Е (60-аас доош): Ажлын гүйцэтгэл нь зохих минимум шаардлагын түвшинд хүрээгүй, маш хангалтгүй ажилласан гэж үзнэ. Ийм үнэлгээ авсан багшийн хөдөлмөрийн гэрээг цуцална.</p>	<p>7.1. А (90-100): <u>Ийм үнэлгээ авсан багшийн ажлын үр дүнг хангалттай сайн гэж үзнэ. Үг багшид зохих урамшуулал олгож болох ба асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.</u></p> <p>7.2. В (70-89): <u>Эрхэлсэн ажилдаа тэнцэж байна гэж үзнэ.</u></p> <p>7.3. С (70-79): <u>Ажилдаа тэнцэж байна гэж үзэх боловч тухайн багшид бага оноо авсан ажлын үзүүлэлтээ сайжруулах хугацаатай даалгавар өгнө.</u></p> <p>7.4. Д (60-69): Ажлын үзүүлэлт хангалтгүй гэж үзэх ба албан тушаалыг нь нэг зэрэглэлээр бууруулж, сургуулийн захиргаанаас тухайн багшид нэг жилийн хугацаатай даалгавар өгч, дараагийн хичээлийн жилийн аттестатчилалд дахин орох боломж олгоно. Энэ үндэслэлээр зэрэглэл буурсан багшийн хувьд дараагийн аттестатчиллын үр дүнгээр өмнөх зэрэглэлдээ дэвшин ажиллах эрх нь хадгалагдана. Дахин аттестатчилалд орохоос таггалзвал хөдөлмөрийн гэрээг цуцална.</p> <p>7.5. Е (60-аас доош): Ажлын гүйцэтгэл нь зохих минимум шаардлагын түвшинд хүрээгүй, маш хангалтгүй ажилласан гэж үзнэ. Ийм үнэлгээ авсан багшийн хөдөлмөрийн гэрээг цуцална.</p>
<p>МУИС-ИЙН БАГШИЙН ОРОН ТОО, АЖЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ</p>	
<p>13. Профессор нь магистрант, докторантын эрдмийн ажлын удирдагч байж, сургалтын үйл ажиллагааны 3 ББц-аас доошгүйг магистр, докторын түвшний сургалтанд хичээл зааж биелүүлсэн байна.</p>	<p>13. Профессор, <u>дэд профессор</u> нь магистрант, докторантын эрдмийн ажлын удирдагч байж, сургалтын үйл ажиллагааны 3 ББц-аас доошгүйг магистр, докторын түвшний сургалтанд хичээл зааж биелүүлсэн байна.</p>
	<p>25. Б6. Эрдэм шинжилгээний бусад ажил</p> <p>2. Мэргэжлийн түвшинд хянагддаггүй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх¹</p> <p>¹⁾ <i>Хамтын бүтээлд багц цагийг зохиогчийн</i></p>

	<i>тооноос хамааруулан 2 хүн хамтарсан бол хүн тус бүрт бүтнээр, 3-5 хүн бол хүн бүрт 0.7, 5-аас дээш бол хүн бүрт 0.5 коэффициентээр тооцно.</i>
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ	
7.1. Сургалтын төв алба нь бакалаврын сургалтын, салбар алба нь шаталсан (бакалавр, магистр, докторын) сургалтын ажлын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавина.	7.1. Сургалтын төв болон салбар алба нь бакалаврын сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг сургалтын стандартад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавина.
	15.15. Оюутан эзэмшихээр суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэшүүлэх хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх нийтлэг шаардлагыг хангахаас гадна 15.8-д заасанчлан мэргэжлийн тэнхим/профессорын багаас тавьсан бусад тусгай шаардлагыг хангасан тохиолдолд хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно.
13.9. Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар сургалтын алба улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно. Дараагийн гурван долоо хоногт оюутан хичээлийн ерөнхий хуваарийг үндэслэн хичээлд бүртгүүлэх ба хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно.	13.9. Ирэх улиралд орох хичээл, анги танхим, цаг, багшийн талаарх мэдээлэл бүхий хичээлийн ерөнхий хуваарийг салбар сургалтын алба улирлын шалгалтын хугацаанд бэлэн болгоно. <u>Оюутан хичээлийн ерөнхий хуваарийг үндэслэн дараагийн улирлын хичээл эхлэх өдрийг хуртэл хугацаанд багтан</u> хичээлд бүртгүүлэх ба хэрэв тухайн хичээлийг судлах оюутны тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд нэрээ бүртгүүлж болно.
20.2.8. Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн, мөн зарим мэргэшүүлэх хичээлийг судалж, 90-ээс доошгүй багц цаг цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн нь 1.8-аас доошгүй тохиолдолд оюутныг зохих нөхцөл, шаардлагаар дээд боловсролын <i>дипломын</i> зэргээр төгсгөж болно.	<u>Бүхэлд нь хасах</u>
20.2.9. Дипломын зэргээр төгсөгч нь төгссөнөөсөө хойш 5 жилийн дотор тухайн мэргэжлээрээ элсэлтийн шалгалтгүйгээр үргэлжүүлэн суралцаж, багц цагаа гүйцээн, бакалаврын зэрэг авч болно.	<u>Бүхэлд нь хасах</u>

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ЖУРАМ

<p>3.1 ТДС нь эрдмийн зөвлөл, захирал, ажилтнаас бүрдэнэ. Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нь төгсөлтийн дараах сургалтыг хариуцна. Бүрэлдэхүүн сургууль төгсөлтийн дараах сургалт хариуцсан ажилтантай байна.</p>	<p>3.2 ТДС нь эрдмийн зөвлөл, захирал, ажилтнаас бүрдэнэ. <u>Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал нь</u> төгсөлтийн дараах сургалтыг хариуцна. Бүрэлдэхүүн сургууль төгсөлтийн дараах сургалт хариуцсан ажилтантай байна.</p>
<p>3.3 ТДС-ийн эрдмийн зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулиудаас сонгогдсон профессорын төлөөллөөс бүрдэнэ. ТДС-ийн эрдмийн зөвлөл нь өөрийн журамтай байна.</p>	<p>3.4 ТДС-ийн эрдмийн зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулиудаас сонгогдсон <u>профессорын төлөөлөл, бүрэлдэхүүн сургуулийн дэд захирлаас бүрдэнэ.</u> ТДС-ийн эрдмийн зөвлөл нь өөрийн журамтай байна.</p>